



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 07 өдөр

Дугаар 4/05

Мандалговь

Газар эзэмших эрхийг
шилжүүлэх тухай


Монгол улсын Газрын тухай хуулийн 38 дугаар зүйл 38.1,2,4 дэх заалт, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 246 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

Нэг. Сайнцагаан сумын 7 дугаар багийн нутаг дэвсгэр (Г.Чагдаржавын гудамж3-300 тоот) байршилтай Дундговь аймгийн Цагдаагийн газар (9033971)-ийн төрийн үйлчилгээний зориулалттай 15077 м.кв (1.5 га) газраас 149 м.кв (0,01 га) газрыг иргэн Жамц овогтой Батаа (ЗЛ:63032719)-д (Г.Чагдаржавын гудамж-3-300а) орон сууцны зориулалтаар нь 16 жилийн хугацаатай эзэмшүүлэхээр эрхийг шилжүүлж, үлдсэн 14928 м.кв (1,49 га) газрыг Дундговь аймгийн Цагдаагийн газар (9033971)-т зориулалтаар нь 16 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

Хоёр. Дээрх байгууллага, иргэнтэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), мөн гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт, Сайнцагаан сумын Засаг дарга, хотын захирагч (Р.Мөнхтогтох), аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга (Ш.Төрбат) нарт үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2004 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 33 дугаар захирамжийн холбогдох хэсэг мөн газар эзэмших 0381938 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488010014